



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн
ажлын цагийг хорогдуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай” А/268 дугаар захирамж, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжиж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан 12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг 1 цагаар хорогдуулж, 09:00–17:00 цагийн хооронд ажиллуулсугай.

2. Дээрх заалтад хамрагдах ажилтнуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Энэ зохицуулалтад хамрагдаж байгаа ажилтнуудын албан үүргийг бүрэн гүйцэтгүүлж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг Захиргааны Ахлах мэргэжилтэн /Б.Номинзул/-д, эдгээр ажилтнуудын цалин хөлсийг ажилласанд тооцон олгохыг нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН